



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ачаа тээврийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Б.Ганхуяг	Нисэх буудлуудын удирдах газрын Нисэх буудлуудын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Уянга	Газрын тусгай үйлчилгээний албаны Чанар баталгаажуулалтын инженер
	Б.Гантулга	Газрын тусгай үйлчилгээний албаны Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Б.Ганцогт	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Ганхуяг/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН